

ӨМНӨД БОЛОН ХОЙД СОЛОНГОСЫН УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ХАРЬЦУУЛСАН АНАЛИЗ

Ж.ТӨРТӨГТОХ

Доктор, профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухасны Салбар,

Улс төр судлалын тэнхим

ПАК ЖОНГ ХҮ

Докторант

Abstract: North and South Korea's political system, political ideology, power structure are very different. In this paper, North and South Korea's political systems are compared, and what ideologies has been affect on political process of two Koreas, also analyzed the power structure of the two Koreas by comparing. In South Korea, ideology of liberal democracy is adopted. But, on actual operation, sometimes it failed and political instability was followed. And the transition to democracy, national sacrifice was needed.

South Korea adopted the single five-year presidential term as a measure to prevent a monopoly of power under previous authoritarian governments when it amended the Constitution in 1987. Since direct election system was adopted, the peaceful transfer of power has been done, the regime's legitimacy is from the people.

In North Korea, ideology of socialism is adopted. And established governmental system which ruled by one man. The core of North Korea's political system is military. According to the constitution of the North Korea, the head of military has a political authority. In the different political system, South and North Korean society is tinged aspects of pluralism and collectivism. It seems not easy to take nation integration among the people of two Koreas after reunification in the future. Course of that political ideology and systems are totally different. It need a desire for reunification between the two Korea's people as of now.

I. Удиртгал

Өнгөрсөн 70-аад жилийн хуваагдлын түүхийг эргэж хархад Өмнөд болон Хойд Солонгос нь тус бүр өөрсдийн амь зуух болон хөгжлийн төлөө эсрэг талтайх сандрал болон сөргөлдөөнийг томруулж ирсэн. Эсрэг талыг үгүйсгэдэг хэрнээсээ хэрэгцээтэй үед хүлээн зөвшөөрөх үе шатыг давтаж ирсэн. Үзэл бодол болон цэргийн эсрэг байдалд Өмнөд Солонгос болон Хойд Солонгос нь бие биенийгээ дайсан хэмээн үздэг хэдий ч, 1970 он болон 1990 онд бараг 20 жилийн зайтай энх тайван болон нэгдэлийн төлөө хичээн тохиролцож байсан удаа ч бий.

1972 онд Өмнөд Хойд Солонгосын нэгдэл нь хоорондоо нөгөө талыг эсэргүүцэх хүч хэрэглэлгүй энх тайван аргаар хэрэгжүүлэн, үзэл бодол болон үнэт зүйл, бодлогын ялгааг даван эхлээд нэгэн үндэстэний хувьд их нэгдлийг үүсгэх ёстой гэсэн [7.4 нийтийн зөвшилцөл] байсан. Мөн 1991 онд улс төр, цэргийн тэмцсэн байдлыг тайлан үндэстэний эвлэрэлийг байгуулан, энх тайвны нэгдлийг үүсгэхийн төлөөх хамтын хичээл зүтгэлийг бататган, Өмнөд Хойд Солонгосын эвлэрэл, Өмнөд Хойд Солонгосын хоорондоо дайрахгүй, Өмнөд Хойд Солонгосын хамтран ажиллагааг чухалчилсан [Өмнөд Хойд Солонгосын ерөнхий тохиролцол] -ийг батласан.

7.4 Хамтийн тохиролцол нь эсрэг байр суурийн бүтцийг сайн санаат өрсөлдөөний бүтэц болгон өөрчлөх гэсэн оролдлого байсан гэж үзэх боломжтой. Гэвч Өмнөд Хойд Солонгос хоёр тал нь Өмнөд Хойд Солонгосын харилцаагаар дамжуулан харин ч илүү тус тусын үзэл бодол болон улс төрийн системийг дахин шалган тус тусын засаглалыг илүү баттай болгох ажилд орсон. Өмнөд Солонгосд 10 сард засаглалын шинэчлэлийг явуулан эрх мэдлийн бүтцийг батжуулсан ба Хойд Солонгосд ч гэсэн хуулийг шинэчлэн нэг хүнийг тахин шүтэх ганц эрх мэдлийн бүтэц орж ирсэн. 1991 оны 9 сарын 17-ны өдөр, Өмнөд Хойд Солонгосын UN-д зэрэг элсэж орсноос хойш, 12 сарын 13-ны өдөр батлагдсан Өмнөд Хойд Солонгосын ерөнхий тохиролцол нь Өмнөд Хойд Солонгос хоорондоо тус тусдаа улсын нэрийг хэрэглэснээр хоорондын тогтолцоог хүлээн зөвшөөрч хүндэлсэн. Гэвч Өмнөд Хойд Солонгосын ерөнхий тохиролцол нь удалгүй харилцааны зогсолоос болж хүчингүй болсон. Хойд Солонгосын NPT-ээс гарсанаас хойш олон үйл явдал тохиолдон 1994 онд Хойд Америкийн Женевын ерөнхий тохиролцол харилцан зөвшилцөн бий болсон ба, Хойд Солонгос нь цаашид Америктай тохиролцон Өмнөд Солонгосыг эсэргүүцэх бодлогыг хэрэгжүүлсэн.

Өмнөд Солонгос болон Хойд Солонгос нь эсрэг бүтцээс гаран энх тайваны дээр эв найрамдал болон хамтын ажиллагаа, мөн нэгдэхийг үргэлжлүүлэн хичээх нь зүйтэй юм. Тиймээс эсрэг хандлагын хамтын харилцаа биш харилцан ашигтай хамтын харилцаа болох бүтцийн өөрчлөлт хэрэгтэй. Үүнд эхлээд шаардлагатай зүйл нь нөгөө талын улс төрийн систем болон эрх мэдлийн бүтцийн талаарх тодорхой ойлголт юм.

Уг судалгааны ажилд Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем болон одоо хүртлэх улс төрийн үе шатанд үүссэн үзэл бодлыг харьцуулах болно. Мөн Өмнөд Хойд Солонгосын эрх мэдлийн бүтцийг харьцуулан анализ хийнэ. Ийм харьцуулсан анализд суурилан Өмнөд Хойд Солонгосын нэгдэх боломжыг хайх гэж байна.

II. Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем болон үзэл бодол

Нэг угсаат үндэстэний хувьд удаан хугацааны түүхийн ёс заншилтай улсыг бүрдүүлж байсан Солонгос улс нь хуваагдлаар дамжуулан Бүгд Найрамдах Солонгос Улс болон Өмнөд Солонгос гэсэн улс төрийн бүлэг үүссэн. Тус тусдаа өөрсдийн уламжлалт чанарыг дэвшүүлэн Өмнөд Солонгос болон Хойд Солонгос нь тус тусдаа чөлөөт ардчилал болон социализмыг суурь болгосон улс төрийн системийг байгуулсан ба бүтэц тус бүр нь өөрсдийн зорьж буй үнэ цэнэ болон үнэт зүйл болон хандлагыг иргэдэд суулгаж ирсэн.

1. Чөлөөт ардчилал болон социализм

Улс төрийн систем гэдэг нь нэг улсын дотор тогтмол улс төрийн үзэл бодол болон зорилгыг биелүүлэхийн тулд улс төрийн үйл ажиллагааг бүлэглэж идэвхтэй улс төрийн амьдралыг байнгын байлгахын төлөөх тогтмол бүтэц болон засгын бодлого болон хэрэгсэлийг агуулсан улс төрийн нэгж юм. Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем нь олон талаас эсрэг үзэл бодлын суурин дээр үүссэн. Өмнөд Солонгосд чөлөөт ардчилалын бүтэц үүсэн. Хойд Солонгосд социализм үүссэн. Чөлөөт ардчилалын систем нь эдийн засгын хувьд зах зээлийн, улс төрийн хувьд намын ардчилалыг сууриар болгосон систем юм.

Чөлөөт ардчилалын улс төрийн систем нь эрх чөлөө болон тэгш байдал гэсэн үнэт зүйлийн үзэл бодлыг бодлого талаас хагахын тулд иргэд төвтэй үзэл болон ерөнхий хүний эрхийн үзэлд суурилсан намын үзэл бодол, хуулийн үзэл, эрхийг гурав хуваасан системийг батласан байгаа. Иргэдийн төвтэй эрх мэдлийн зарчим нь чөлөөт ардчилалын захиргааны гол буюу улсын шийдвэрийг хамгийн эцэст шийдвэрлэж чадах хамгийн дээд эрх мэдэлтэн нь иргэн гэдгийг илэрхийлнэ. Эрх мэдлийн хуваарилалтын зарчим нь улсын эрх мэдлийг олон байгууллагад хуваариласнаар эрх мэдлийн хоорондын хязгаарлалт болон тэнцвэрээр дамжуулан эрх мэдлийн бөөгнөрөл болон дүрэмт бус эрх мэдлийн ашиглалтаас сэргийлж байгаа юм. Өмнөд Солонгосд хуулийн эрх мэдэл нь УИХ болон эдийн засгын алба, хуулийн албын тус байгууллага бүрт хуваарилагдсан байгаа.

Хойд Солонгосын социализм нь үйлдвэрлэлийн аргаар хувийн өмчит зах зээлийн эдийн засгыг голдуулсан зах зээлийг эсэргүүцэн, гадны удирдагч сонгох системийг эсэргүүцэн ажилчин ангын улс төрийн дарангуйлалыг хэрэгжүүлэхийн тулд иргэд эзэний байр суурийг авдаг систем юм. Тиймээс Хойд Солонгосын социализмд ардчилалын эрх мэдлийн төвлөрөх систем болон намын дарангуйлалыг өөрийн онцлого шинж болгож байна. Ардчилалын эрх мэдлийн төвлөрөх системийн зарчмын дагуу төлөөлөгч байгуулагт эрх мэдэл төвлөрдөг.¹ Иргэн төвт онцолт суурилсан ардчилалын эрх мэдлийн төвлөрөх систем нь иргэний эрх мэдлийн зарчимд суурилсан удирдагч сонгох систем болон эрх мэдлийн хуваарилалтын зарчимтай эсрэг байр суурьд байгаа. Иргэн төвт зарчмын хувьд нийт иргэн үндсэн хууль тогтоохоос эхлээд хууль тогтоох хүртэлх бүх зүйлийг өөрөө хариуцах ёстой гэж хэлдэг. Чөлөөт ардчилалын системд хувь хүний эрх чөлөөг хамгаалахын тулд улсын эрх мэдлийг хуваарилах нь зайлшгүй хэдий ч Хойд Солонгосын социализмын системд ардчилсан эрх мэдлийн төвлөрөлийн зарчмаар төлөөлөгч байгууллагад эрх мэдэл төвлөрдөг. Хойд Солонгосын социализмын системд төлөөлөгч байгууллага нь улсын оршин тогтнох үндэс болж, хамгийн дээд улсын эрх мэдэлт байгуулгын хувьд бусад улсын байгууллагаас дээр оршин болно.² Хойд Солонгосын социализмын системд эрх мэдлийн хуваарилалт няцаагддаг ба төлөөлөгч байгууллага хуулийн хувьд улсын хамгийн дээд эрх мэдэлт байгуулгын байр суурийг эзлэж байгаа хэдий ч бодит байдал дээр нам хамгийн дээд эрх мэдэлт байгуулгы хувьд намын захирагадалт явагдаж байгаа.³

2. Олон зарчимт үзэл болон бүлгийн эрх ашигын үзэл

1) Олон зарчимт үзлийн үнэ цэнэ болон ардчилал

Өмнөд Хойд Солонгосын хоёр талын системийн хамгийн ид тод ялгааг харуулж байгаа хээг нь

¹ Хойд Солонгосын үндсэн хуулийн 5-р бүлэгт "Хойд Солонгосд бүх улсын байгууллагууд нь ардчилалын төвийн эрх мэдлийн төвлөрлийн зарчмаар бүлэглэж, үйл ажиллагааг явуулна" хэмээн заасан байгаа.

² Хойд Солонгосын үндсэн хуулийн 87-р бүлэгт "их иргэдийн хурал нь Хойд Солонгосын хамгийн дээд эрх мэдэлт байгууллага юм."

³ Хойд Солонгосын үндсэн хуулийн 11-р бүлэгт "Хойд Солонгос нь Хойд Солонгосын Ажлын ангийн намны удирдлагын дор бүх үйл ажиллагааг явуулна" Хэмээн бичигдсэн байгаа учир, намыг эхэнд тавих зарчмыг дагаж байгаа.

Өмнөд Солонгосын чөлөөт ардчилалын улс төрийн системийн үзэл бодол болон Хойд Солонгосын социализмын үзэл бодол юм. Өмнөд Солонгосын чөлөөт ардчилалын үнэ цэнэ нь хувь хүнийг зорилгоо болгон хувь хүний нэр төр болон үнэ цэнийг хадгалан өндөрт өргөхийг улс төрийн системийн үндсэн зориг болгож байгаа учир нийгмийн талаас олон зарчимт үзлийг хангах хэрэгтэйг анхааруулдаг. Хувь хүний үзлийн хөгжил байхгүй бол олон зарчимт үзэл хөгжих боломжгүй. Тиймээс чөлөөт ардчилалын системд хувь хүний эрх чөлөө болон нэр төр нь улс төрийн эмх замбарааг үүсгэхийн сууриас илүү чухал байр суурь эзлэж байгаа ба улс төрийн уламжлалт байдалт чухал байр суурьтай байгаа.

Өмнөд Солонгосд улс төрийг барьж буй эрх мэдлийн төврөлсөн бүлэг нь нийтлэг даяарчлалын урсгал гэж хэлж болох орчин үеийн даалгавар болох "эдийн засгийн хөгжил" болон "ардчилал", "нэгдсэн иргэний улсыг байгуулах" гэсэн улсын зоригийг урдаа тавьж байсан. Мөн түүний дээр дэлхийн зэвсэггүй хүйтэн дайны үеийн Америка нэгдсэнээр олж авсан "социализмын эсрэг үзэл"-ийг дээд зорилго болгон нэмсэн. Тиймээс Солонгосын дайнаас хойш үргэлжлүүлэн Өмнөд Хойд Солонгос тэмцэлдэж байгаа нөхцөлд социализмын эсрэг байхыг чөлөөт ардчилалын үнэ цэнээс дутахааргүй чухал улс төрийн зоригоо болгосон. Тиймээс, чөлөөт ардчилалыг хамгаалахын тулд социализмын эсрэг байх ёстой, тийм учир чөлөөт ардчилалыг хязгаарлахгүй байх аргагүй гэсэн зүйл юм. Социализмын эсрэг болон эдийн засгийн хөгжлийг үндэсний нэгдэл болон ардчилалаас илүү чухал дээд байр сууринд тавьж үүнийг иргэдэд суулгаан. Тиймээс социализмын эсрэг үзэл болон хөгжлийн үзэл нь үр дүнтэй нийгмийн нэгдлийг гүйцэтгэсэн.

Гэвч орчин үеийн Солонгосын улс төрд ардчилалын даалгавар нь бодит байдалд чөлөөт ардчилалыг байгуулан, ардчилалд социализмын эсрэг үзэл юм уу хөгжлийн үзлээс илүү эхэн байр суурыг олгох юм уу түүнтэй зэрэгцэх байр суурыг олгох байсан.

1980 оны сүүлээр Өмнөд Солонгосын улс төрийн нийгэм нь ардчилал руу чиглэсэн гал халуун байдлаар дүүрсэн. Өмнөд Солонгосын ардчилалын тэмцэлийн хамгийн идэвхитэй байсан нь 1987 оны 6 сарын ардчилалын тэмцэл байсан бөгөөд, оюутнуудын бослогонд иргэд хамрагдах болсон. Үүний үр дүнд ерөнхийлөгчийн шууд сонгуулыг гол болгосон 6.29 тунхаг тунхаглагдсан ба, үүнээс хойш хөгжлийн үзэл бодолд золиослогдсон ажилчдын ангын шаардлага хүчтэй ялгарсан.

Иргэдийн ардчилалын хичээл зүтгэл нь шууд сонгуулын хууль тогтоох болон ерөнхийлөгчийн сонгуул болж үргэлжлэсэн хэдий ч өнгөрсөнд цэргийн бүлгийн өв залгамжласан бүлэг эрх мэдлийг авах болсон. Гэхдээ улс төрийн эрх мэдлийг урдаа тавьх юм уу хүсэмжлэдэг үзэл бодол нь өөрчлөлтийг авчирсан. Өмнөд Солонгосд ардчилал нь социализмын эсрэг үзэл бодол юм уу хөгжлийн үзэл бодолыг сулруулсан. Энэ нь 30 орчим жилийн турш эдийн засгийн хөгжлийн үр дүнгээр Хойд Солонгостойх системийн өрсөлдөөнд давуу байдлыг олсны үр дүн гэж хэлэх боломжтой. Мөн 1980оны сүүлээс эхлэн хурдтай явагдсан социализмын орнуудын нуралт болон түүнийг дагасан Хойд Солонгосын байр суурийн сулрал ч өмнөх үзэл бодол дамжил, өөрчлөлтөнд нөлөө үзүүлсэн.

2) Объектийн хүчирхэг улс байгуулах болон цэргийг татахад удирдах

Социализмтай улс Хойд Солонгосд объектийн үзэл нь нам болон улсын үйл ажиллагаа, хувьсгал болон байгуулах үйл ажиллагааны удирдах зарчмыг шийдвэрлэж буй хамгийн дээд удирдах үзэл юм. 1955онд анх Хойд Солонгосд гарч ирсэн объектийн асуудал нь ЗХУ болон Хятадаас өөрийгөө хамгаалах болон улсын эрх ашигын төлөөх биеэ даах чанарыг тодруулах болон тухайн үеийн амиа хичээсэн бүлэг хүмүүсийг устгах, мөн орчин үеийн болох шаардлагаас гар ирсэн юм.

Түүнээс хойш Хойд Солонгосд захиргаадах үзэлээр объектийн үзэл гэсэн үгийг хэрэглэх болсон ба, 1970 онд ажлын ангийн намын 5-р хуралд Маркс-Ленины үзэлтэй хамт амын албан ёсны үзэл бодол болсон. 1972 онд үндсэн хуулийн шинэчлэлт болон 1980 онд ажлын ангийн намын 6-рхурал, мөн 1992 оны үндсэн хуулийн шинэчлэлтээр дамжуулан объектын үзэл нь Хойд Солонгосын хамгийн дээд удирдах үзэл болон тогтоогдсон.⁴

Объектын үзэл нь эцэст бүлгийн үзлийг сууриа болгосон ахлагчын захиргаалын ойлголт юм.⁵ Объектын үзэл нь бүлгийн эрх ашигыг хувь хүний эрх ашигаас дээр тавьдаг ба бүлгийн эрх ашигыг дэмжихийг хувь хүн болгоны эрхэм нандин үүрэг гэж үздэг.⁶

⁴ 1992 он 4 сард шинэчлэгдсэн үндсэн хуулийн 3-р бүлэг, "Хойд Солонгос нь хүл төвт үзэл бөгөөд иргэдийн биеэ даах чадварыг гүйцэтгэхийн тулд объектын үзлийг өөрийн үйл ажиллагааны удирдлага болгоно."

⁵ Хойд Солонгосын үндсэн хуулийн 63-р бүлэг, "Хойд Солонгосд иргэдийн эрх болон үүрэг нь <нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгний төлөө> гэсэн бүлгийн үзлийн зарчимд суурилдаг" гэж бичигдсэн.

⁶ Ли Жин Гюү, 1988, 「Объектын улс төрийн онол」, 동경: 우월서방, p.455

Бүлгийн эрх ашигыг ахлагч төлөөлөн, бүлгийн хамгийн дээд ахлагч гэдгийн хувьд ахлагч гэдэг ойлголт нь хү төвт объектын философид шинээр нээгдэн үүссэн философын ойлголт юм. Энэ нь иргэд, олон нийт, үндэстэн гэсэн бүлгийн ойлголттой нэгдсэн ойлголт юм.⁷ Хойд Солонгосын социализмын ардчилалын давуу чанар нь нийгмийн улс төрийн үзэл бодлын нэгдэлд ч гэсэн тод илэрдэг.⁸ Үүнээс хойш Хойд Солонгосд “Манай үндэстэн хамгийн дээр үзэл” болон “Манай хэв маягын нийгэм үзэл”-ийг урдаа тавьсан. Энэ нь 1980 оны сүүлээс хойш гарч ирсэн социализмын уналтыг дагасан Хойд Солонгосын хэв маягын социализмын системийн зөвт байдлыг хамгаалах тал дээр гаргаж ирсэн зүйл юм. Хойд Солонгос нь 1998 он 8 сарын 22-нд ажилчин сонингоор дамжуулан “гайхамшигт намын удирдлагыг даган социализмын хүчирхэг улсыг бүтээцгээе” гээд “хавчлагт зам”-ийн оронд социализмын хүчирхэг улсын онолыг гаргасан. Мөн Хойд Солонгос нь 1999 онд шинэ оны мэндчилгээгээр дамжуулан “хүчирхэг улсыг бүтээхэд шинэ замыг нээхийн тулд бидний хэв маягын хувьсгалыг яс биелүүлэх ёстой. Нам, цэрэг, иргэний нэгэн сэтгэлээр нэгдэхийн хүч, улс төрийн үзлийн хүчийг идэвхжүүлэн өөрсдийн хүчээр бүхнийг бүтээх нь бидний хувьсгал юм. Удирдагчыг төвөө болгож бидний нэгэн сэтгэлийг батжуулан тэр хүчээр социализмын байгуулалыг бүтээх ёстой” хэмээн хэлсэн.

Ингэж 1998 оноос илэрхийлэж ирсэн хүчирхэг улс байгуулах үзэл нь 2000 оноос үзэл бодол болон удирдлага, шинжлэх ухаан технологи нь хүчирхэг улс байгуулахын гурван багана гэж тодорхойлон үүний чухал чанарыг тодотгож ирсэн. Энэ нь 1990 онд илэрхийлж байсан манай хэв маягын социализм болон манай хэв маягын хувьсгалын аргын давуу талыг дахин тодруулан, удирдагчыг төвөө болгон нэгдэх хэрэгтэй гэсэн үг юм. Хойд Солонгос нь иргэддээ бат нийлж хэцүү зовлонг давж ирсэн ба одоо хүчирхэг улс болох ажллагаа явагдаж байгаа тул итгээд дага гэж хэлж байгаа. Энэ нь одоог хүртэл зовлонтой аян замаар иргэдийн золиослолыг тулгаж ирсэн бол, одооноос өөртөө итгэх итгэлийг суулгаж өгөх ёстой учир юм.

Одоогоор Хойд Солонгосын илэрхийлж байгаа, мөн иргэддээ суулгах гэж байгаа үзэл нь объектын хүчирхэг улс байгуулах юм. Энэ нь Хойд Солонгосыг сэргэлттэй хүчирхэг улс болгоно гэж байгаа бөгөөд, ингэхийн тулд Ким Жонг Ил-ийн цэрэг удирдах арга нь зайлшгүй.

III. Улс төрийн эрх мэдлийн бүтэц болон систем

Урд харсанчлан Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем нь өөр бөгөөд мөн зорьж байгаа үзэл бодол ч өөр. Тиймээс Өмнөд Хойд Солонгосын улс төрийн эрх мэдлийн бүтэц ч өөр бөгөөд, тус бүрийн систем ч өөр болохоос өөр аргагүй. Мөн систем нь шийдвэрийн хамгийн дээд хариуцагч хэн гэдгээс шалтгаалж өөрчлөгддөг. Өмнөд Хойд Солонгосын эрх мэдлийн бүтэц болон үүнээс үүссэн системүүдийг харьцуулвал дараахтай адил.

1. Ерөнхийлөгч төвт систем

Ерөнхийдөө чөлөөт ардчилалын системд төрийн хэлбэр нь УИХ-ийн систем боло ерөнхийлөгчийн системийг сонгож байна. Ерөнхийлөгчийн систем нь эрх мэдлийн хуваарилалт нарын чанга явагддаг ба эрх мэдэлт байгууллагуудын хоорондын тусгаар тогтносон байдал батлагддаг ба, ерөнхийлөгч тусгаар тогтнож үйл ажиллагааг явуулах төрийн засаглалын хэлбэрийг хэлнэ. Ерөнхийлөгчийн системд ерөнхийлөгч нь улсын ахлагч байхын зэрэгцээ үйл ажиллагааны дээд байранд байгаагын хувьд улсыг төлөөлөхийн зэрэгцээ дотоод бүтэцийг бүрдүүлэх эрхтэй. Тиймээс гол хэрэгжүүлэх албаны тухай бодлогын шийдвэрлэх эрх нь үйл ажиллагааны албаны тэргүүн болон ерөнхийлөгчийг нэг төвийн зохицуулах байгууллагад төвлөрсөн байгаа. Одоогын төвийн зохицуулах байгууллага нь ерөнхийлөгчийн нарийн бичгийн албаны үүргийн зохицуулгын дор ерөнхий сайд, санхүү эдийн засгийн алба, аюулгүй байдлын үйл ажиллагааны алба зэрэг төвийн үйл ажиллагааны байгууллага үе шаттай ажиллаж байгаа. Гэвч эрх мэдлийн хуваарилалтын зарчимд үнэнчээр хандсаны үр дүнд хуулийг шинэчлэх болон үйл ажиллагаа явуулах нь шаардлагагүй салж төрийн нэгдсэн үйл ажиллагаанд саад болох ч боломжтой. Ерөнхийлөгчийн харьяат нам болон УИХ-ийн олон нам нэгдсэн үед асуудал байхгүй ч тийм биш тохиолдолд үйл ажиллагааны алба болон хууль шинэчлэлийн албаны мөргөлдөөнийг зохицуулахад хэцүү болно. Гэвч Өмнөд Солонгосын үндсэн хуулийн шинэчлэлтийн түүхийг хархад харин ч УИХ-ийн эрхийн хязгаарлалт асуудал болж байсан.

1960-аад оноос 1980 оныг хүртэл Өмнөд Солонгосд төрийг харууцан удирдаж байсан ерөнхийлөгч нь хүчтэй эрх мэдэлтэй байр сууринд байсан. 4-р холбоот улсаас ерөнхийлөгч нь яаралтай зохицуулах эрхийг авах зэрэг гурван эрх мэдлийн хуваарилалтын хуулийн шинэчлэлтийн ойлголтонд

⁷ Ку Ёнг Хуан, 1989, [Манай үндэстэн хамгийн дээд онол], Пёньян: Пёньянчунпванса, р130

⁸ Ли Ги Соб, 1987, [Социализмын ардчилал], Пёньян: 사회과학출판사

хязгаарлагддаггүй байсан. Ерөнхийлөгч нь УИХ-ийг тараах эрхийг авсан ба УИХ-ийн төрийг шалгах эрх хаагдсан. 5-р холбоот улс ч мөн ерөнхийдөө шинэчлэх системийг залгамжилсан шинж чанартай байсан. Дарамт болон удирдагчын дээд албан тушаалаас болж УИХ-ийн нэр төр маш сул дорой байсан. 6-р холбоот улс гарч ирсэнээс хойш хуулийн тал дээр УИХ-ийн биеэ даасан чанар нэмэгдсэн. Ерөнхийлөгчийн УИХ тараах эрх хасагдан УИХ-ийн засгийн газрыг шалгах эрх сэргэсэн.

Өмнөд Солонгосын үндсэн хууль нь 9-р шинэчлэлтээр 1987 он 10 сарын 29-нд тунхаглагдсан. Уг үндсэн хуулийн хамгийн том онцлого нь ерөнхийлөгчийг шууд сонгуулаар сонгох бодлогыг сэргээсэнд оршино. Уг үндсэн хуулиар дамжуулан өмнөх цэргийн төрийн залгамжлагч болон Ну Тэ Ү ерөнхийлөгчөөс Ким Ёнг Сам ерөнхийлөгч руух төрийн солигдол болон Ким Ёнг Сам-аас Ким Дэ Жүнг руух төрийн солигдол, мөн Ну Мү Хён-ийг дамжин И Мёнг Бак, Пак Гүн Хэ ерөнхийлөгчийг хүртэл энх тайван байдлаар төрийн солигдлыг бий болгосон. Тиймээс энэ үндсэн хуулийн найдсан зорилгыг биелүүлэхэд амжилттай үндсэн хууль гэсэн үнэлгээг авч байгаа.

Тиймээс үндсэн хуулийн эрх мэдлийн бүтэц юм уу ерөнхийлөгчийн системийн дор улс төрийн эрх мэдэл нь Ну Тэ Ү, Ким Ёнг Сам, Ким Дэ Жүнг, Ну Мү Хён, И Мёнг Бак, Пак Гүн Хэ төрийг хүртэл адилхан. Хэрин УИХ-тайх харилцаанд үндсэн нам олон тоог эзлэж байгаа юу, тийм байж чадахгүй байгаа юу гэдгээс шалгаалж эрх мэдлийн хязгаар байх эсэх нь шийдэгддэг. Эсрэг намын УИХ гишүүдийн тоо үндсэн намаас их байгаа тохиолдолд, ерөнхийлөгч эрх мэдлээ ашиглах буюу бодлогыг батлах тал дээр хязгаар авж байгаа. Тиймээс өнгөрсөн үеийн ерөнхийлөгчид өөрийн намын УИХ гишүүдийн тоог ихэсгэхэд анхаарч байсан.

2. Ахлагч төвт систем

Хойд Солонгосын социализмын системд төвийн эрх мэдэлт нам нь улс төрийн эрх мэдлийг монополидон, нам, ажилтны системийг улсын ажилтаны системийн дэр тавин нийгмийн бүх бүлэг юм уу шийдвэр нь намын шийдсэн зоригыг биелүүлэхийн тулд ажилладаг систем юм. Хойд Солонгос нь 1972 оны 12 сарын 27-нд шинэ үндсэн хуулийг батласнаар бүх эрх мэдэл нэг газар төвлөрсөн төвлөрсөн системийг байгуулсан. Мөн дотоод боло намын хэсэг үүргээр дамжуулан нэгтгэсэн улсын эрх мэдлийн хамгийн дээд удирдах байгууллагаар төвийн иргэдийн хуралыг мөн үүсгэсэн. Ким Ил Сонг нь Хойд Солонгосын ажилчдын намын нийт нарийн бичиг бөгөөд, төв эрх мэдэлтэн бөгөөд, төв иргэдийн хурлын дарга байсан. 1998 оны 9 сарын 5-нд үндсэн хуулийг шинэчилснээр дамжуулан одоог хүртэлх үндсэн хуулинд хамгийн дээд ахлагч байсан ахлагчын систем хаагдан, түүний оронд Ким Ил Сонг-ийг мөнхийн ахлагч болгоно хэмээн үндсэн хуулинд тэмдэглэсэн. Төвий иргэдийн хурал хаагдан, үйл ажиллагааны алба ч дотоодод шилжин байр сууриа бататгасан. Мөн хамгийн дээд иргэдийн хуралд харьяа хурлыг үүсгэн гадна төрхөнд тодорхой хэмжээний үүрэг болон эрхийг олгосон. Мөн өмнөх үндсэн хуулинд байгаагүй “дотоод ерөнхий сайд нь Хойд Солонгосын төрийг төлөөлнө” гэсэн хэсгийг нэмэн, дотоод байр суурийг бататгасан.

Ким Жонг Ил-ийн системийн эхлэл гэж болох 1998 оны үндсэн хуулийн шинэчлэлтийг даган хамгийн утга өгөгдсөн зүйл нь цэргийн хэсгийг хүчирхэгжүүлснээр системийн аюулгүй байдлыг хангасан юм. Үндсэн хуулийн шинэчлэлтэнд цэргийн алба нь “улсын эрх мэдлийн хамгийн дээд цэргийн удирдах байгууллага бөгөөд нийт цэргийн зохицуулах байгууллага” хэмээн тодорхойлогдож, цэргийн алба нь цэргийн хэсгийн хамгийн дээд эрх мэдэл болон үйл ажиллагааны байгууллагын хувьд цэргийн үйл ажиллагааг нийтэд нь нэгтгэж захиран удирдах болсон, Гэвч цэргийн албаны дараг нь нийт цэргийн хүчинг захирахаас гадна, цэргийн ажилыг нийтэд удирдах улсын хамгийн том албан тушаал бөгөөд улсын улс төр, цэрэг, эдийн засгыг нийтэд удирдах эрх мэдэлтэй болсон. Энэ нь Хойд Солонгосын хамгийн дээд иргэдийн хурлын дээд гишүүдийн дарга болон Ким Ёнг Нам Ким Жонг Илийг цэргийн албаны дарга хэмээн дээдлэснээр тодруулсан зүйл бөгөөд бодитоор Хойд Солонгосд цэргийн албаны дарга улсын хамгийн том албан тушаал юм.

Цэргийн албаны дарга нь үндсэн хуулинд гадна төрхөөр их өөрчлөгдөөгүй хэдий ч үндсэн хуультай хамаагүйгээр бодит хамгийн их эрх мэдэлтэн юм. Ким Жонг Ил-ийн төрийг тулж өгдөг гол бүлэг нь цэрэг учир, цэргийн нөлөө нь бүх гадна дотны бодлогыг шийдвэрт хүчтэй нөлөөлдөг. Бодитоор Хойд Солонгосд сайн улс төр нь “социализмын онцгой улс төрийн хэв маяг” хэмээн тодорхойлон, Ким Жонг Ил нь үүнийг “бүхнийг бүтээх сэлэм” хэмээн нэрлэсэн. Сайн улс төр нь юуны түрүүнд цэргийг хүчирхэгжүүлж түүнд тулгуурлан социализмыг даган, хувьсгал болон байгуулах үйл ажиллагааг явуулдаг онцгой улс төрийн хэв маяг юм.

Эцэст нь Ким Жонг Ил өөрийнхөө харуулах ёстой улсын ахлах албан тушаалыг устган, оронд нь нам болон цэргийн хүчинг гартаа авч, оронд нь үйл ажиллагаа болон эдийн засгийн талбарыг мэргэжлийн

ажилчдад даатган гадна төрхөөрөө төрийн хариуцлагыг хуваариласан хэрнээ, бодит байдал дээр өөрөө цорын ганц эрх мэдэл байж болох бүтэцийг бэлдсэн ба, энэ нь түүний өв залгамжлагч болох Ким Жонг Ун-ий үеийг хүртэл уламжлагдаж ирч байна.

IV. Үр дүн

Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем, улс төрийн үзэл бодол, эрх мэдлийн бүтэц нь маш өөр талуудыг харуулж байна. Өмнөд Солонгосын хувьд чөлөөт ардчилал системийн хувьд зайлшгүй байх үзэл бодол болон тохируулагдсан. Гэвч чөлөөт ардчилалын улс төрийн системийн бодит үйл ажиллагааны бүтэлгүйтлээр улс төрийн амар тайван бус байдал дагаж ирсэн ба, ардчилалын улс төрлүү хөтлөх замд золиос ч байсан. 1987 оны ерөнхийлөгчийг сонгох хууль батлагдсанаас хойш чөлөөт сонгуулаас үүссэн төрийн солигдол бий болж ирсэн ба, төрийн зөвт байдлыг иргэдээс хүртсэн ерөнхийлөгчийг төвөө болгон төр үйл ажиллагаагаа явуулж байна. Хойд Солонгосын хувьд социализмын үзэл бодлоос шалтгаалж иргэдээр хийгдэх захиргааталыг гаргаж ирсэн хэдий ч, нийгмийн амьд биеийн онолыг урдаа тавьж нэг хүнээр үүсгэгдэх захиргааталыг зөвтгөсөн. Ахлагчын удирдлагаар дамжуулан иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх үе шатаас тусгаарлагдмал байх бүтэцтэй ардчилсан төвийн эрх мэдлийн системийг үүсгэсэн. Өнгөрсөнд ахлагчын авч байсан эрх мэдэл нь гадна төрхийн хувьд хуваарилагдсан байгаа ч түүний голд цэргийн хүчин байгаа ба, түүний ахлагч болох цэргийн албаны дарга хамгийн дээд эрх мэдэлтэн болох боломжтой улс төрийн системийг бүрдүүлсэн. Ингэж хоорондоо өөр захиргааны бүтцийн дотор Өмнөд Хойд Солонгосын нийгэм нь олон зарчимт үзэл болон бүлгийн үзлийн хэв маягийг агуулж байна.

Өмнөд Хойд Солонгосын улс төрийн систем юм уу үзэл бодол, эрх мэдлийн бүтэц хоорондоо өөр байгаагаас шалтгаалж хойд үед нэгдэл юм уу үндэстний нэгдэл хялбар зүйл биш болсон. Одоо шууд хууль, системийн нэгдэл юм уу нэгтгэлээс илүү Солонгосын газар нутгын тайван байдал болон амар тайвныг батжуулах нь одоогын биелүүлэх зүйл юм. Цаашид нэгдлийн төлөө, үндэстний хөгжил болон ирээдүйн төлөө нэгэн үндэстэн тэмцэж байгаа байдал батжиж болохгүй гэсэн үндэстэний хүсэл суурь болох ёстой.

Номзүй

1. 고영환, 1989. 『우리 민족제일주의론』, 평양: 평양출판사.
2. 권만학, 2000. “새천년의 통일과 대북정책”, 백경남, 송하중 외, 『새천년의 한국정치와 행정』, 서울: 나남출판.
3. 김광석, 1994. “북한의 통일방안에 대한 법적 검토”, 『북한연구』, 제5권 3호, 대륙연구소.
4. 김동남, 2001. “위대한 령도자 김정일동지의 선군정치는 사회주의 경제강국건설의 결정적 담보”, 『경제연구』, 류계 제111호, 평양: 과학백과종합출판사.
5. 김정일, 1982. 『주체사상에 대하여』, 평양: 조선로동당출판사.
6. 김정일, 1994. 『사회주의는 과학이다』, 평양: 조선로동당 중앙위원회.
7. 김창희, 2006. 『북한정치사회의 이해』, 서울: 법문사.
8. 김창희, 2012. 『북한정치와 김정은』, 서울: 법문사.
9. 리기섭, 1987. 『사회주의적 민주주의』, 평양: 사회과학출판사.
10. 리동구, 2001. “‘내각중심제, 내각책임제’는 경제사업에 대한 국가의 통일적 지도관리형태”, 『김일성종합대학학보: 철학경제학』, 제47권 1호, 김일성 종합대학출판사.
11. 리진규, 1988. 『주체의 정치론』, 동경: 구월서방.
12. 안인해, 1999. “‘김일성헌법과 김정일체제’”, 『한국정치학회보』, 제32집 4호, 한국정치학회.
13. 이상우, 2014. 『북한정치 변천: 신경제체의 진화과정』, 서울: 오름.
14. 정성장, 2011. 『현대북한의 정치』, 서울: 한울아카데미.